



**ДИПЛОМАТ ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ  
ВИЗИЙН ШААРДЛАГААС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохиролцогч Талууд” гэх/,

хоёр талын харилцааг цаашид бэхжүүлэн хөгжүүлэх эрмэлзлийг удирдлага болгон,

иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх зорилгоор,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов.

**1 дүгээр зүйл**

Монгол Улсын хүчин төгөлдөр дипломат паспорт бүхий иргэд Бүгд Найрамдах Франц Улсын нутаг дэвсгэрт болон тус улсын далайн чанад дахь муж, департамент болон Шинэ Каледонид (албан ажлаар болон хувийн хэргээр) зорчихдоо Шенгений бүсэд буюу Бүгд Найрамдах Франц Улсын дээр дурдсан бүх нутаг дэвсгэрт нэвтрэн орсон өдрөөс эхлэн зургаан (6) сарын хугацаанд хэсэгчлэн эсхүл бүхэлд нь нийт ер (90) хоног виз авах шаардлагаас чөлөөлөгдөнө.

**2 дугаар зүйл**

Бүгд Найрамдах Франц Улсын хүчин төгөлдөр дипломат паспорт бүхий иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт (албан ажлаар болон хувийн хэргээр) зорчихдоо Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсон өдрөөс эхлэн зургаан (6) сарын хугацаанд хэсэгчлэн эсхүл бүхэлд нь нийт ер (90) хоног виз авах шаардлагаас чөлөөлөгдөнө.

### **3 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч Талуудын дипломат паспорт бүхий иргэд энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр болон 2 дугаар зүйлд дурдсан хугацаанаас илүү хугацаагаар зорчих тохиолдолд виз мэдүүлж авах шаардлагатай болно.

Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэг улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар болон Олон улсын байгууллагад томилогдон ажиллах нөгөө Талын хүчин төгөлдөр дипломат паспорт бүхий иргэн хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө аккредитацийн виз авах үүргээс энэхүү хэлэлцээрээр чөлөөлөгдөхгүй.

### **4 дүгээр зүйл**

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын дипломат паспорт бүхий иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа хүлээн авагч улсын хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын гэрээг даган биелүүлэх үүргийг энэхүү Хэлэлцээр хөндөхгүй.

### **5 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрсдийн хэрэглэж буй, шинэчлэгдсэн дипломат паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцож, дипломат паспорт олгох, ашиглах нөхцөлийн талаар харилцан мэдээлж байна.

Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрсдийн ашиглаж буй дипломат паспорт болон түүнийг олгох, ашиглах журамд өөрчлөлт оруулах тохиолдолд тухай өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос жар (60) хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, шинэчилсэн дипломат паспортын загварыг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хүргүүлнэ.

Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр дипломат паспорт үрэгдсэн, хулгайд алдагдсан эсвэл хүчингүйд тооцсон тухай мэдээллийг жар (60) хоногийн дотор Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа мэдэгдэнэ.

### **6 дугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээрийн заалтыг тайлбарлахтай холбоотой үүссэн аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч Талууд дипломат шугамаар зөвшилцөх буюу хэлэлцээ хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

### **7 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эсхүл нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно.

Ийнхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох тухай мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шуугамаар мэдэгдэнэ.

### 8 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хугацаагүй байгуулсан болно.

Хэлэлцэн тохиролцогч Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Хэлэлцээрт оруулж буй нэмэлт өөрчлөлт нь энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийг Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа бичгээр хүргүүлсэн мэдэгдлийн дагуу цуцалж болно. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ер (90) хоногийн дараа хүчингүй болно.

### 9 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шуугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдэлийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр (2) дахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.


Дээр дурдсаныг нотолж, энэхүү Хэлэлцээрт Засгийн газраас өгсөн бүрэн эрхийн дагуу гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2013 оны 10 дугаар сарын 26-ны өдөр монгол, франц хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



**БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**





**ACCORD ENTRE  
LE GOUVERNEMENT DE LA MONGOLIE  
ET  
LE GOUVERNEMENT DE LA RÉPUBLIQUE FRANÇAISE  
SUR L'EXEMPTION RÉCIPROQUE DE VISAS DE COURT SÉJOUR  
POUR LES TITULAIRES D'UN PASSEPORT DIPLOMATIQUE**

Le Gouvernement de la Mongolie et le Gouvernement de la République française, ci-après dénommés les « Parties »,

Animés du désir de favoriser et de développer leurs relations bilatérales, et de faciliter la circulation de leurs ressortissants,

Sont convenus de ce qui suit :

**Article 1<sup>er</sup>**

Les ressortissants de la Mongolie (se déplaçant en mission ou à titre privé) titulaires d'un passeport diplomatique en cours de validité ont accès sans visa au territoire de la République française, à savoir l'ensemble des départements français métropolitains ainsi que les départements et régions d'outre-mer (DROM), les collectivités d'outre-mer (COM) et la Nouvelle-Calédonie, pour un séjour ininterrompu ou plusieurs séjours dont la durée totale ne dépasse pas quatre-vingt-dix (90) jours au cours d'une période de six (6) mois à compter de la date de la première entrée dans l'espace Schengen ou dans toute partie du territoire la République française non comprise dans cet espace.

**Article 2**

Les ressortissants de la République française (se déplaçant en mission ou à titre privé) titulaires d'un passeport diplomatique en cours de validité ont accès sans visa au territoire de la Mongolie pour un séjour ininterrompu ou plusieurs

séjours dont la durée totale ne dépasse pas quatre-vingt-dix (90) jours au cours d'une période de six (6) mois à compter de la date de la première entrée sur le territoire de Mongolie.

### **Article 3**

Les ressortissants de l'une ou l'autre Partie titulaires d'un passeport diplomatique sont dans l'obligation d'obtenir un visa pour un ou plusieurs séjour(s) d'une durée supérieure à celle qui est mentionnée aux articles 1<sup>er</sup> et 2 du présent Accord.

Le présent Accord n'exempte pas les ressortissants d'une Partie titulaires d'un passeport diplomatique en cours de validité, nommés auprès des missions diplomatiques ou des postes consulaires de cette Partie sur le territoire de l'autre Partie, ou représentants de cette Partie auprès des organisations internationales qui ont leur siège sur le territoire de l'autre Partie, de l'obligation d'obtenir un visa aux fins de leur accréditation par l'État d'accueil antérieurement à leur arrivée.

### **Article 4**

Les ressortissants de l'une ou l'autre Partie titulaires d'un passeport diplomatique, visés par le présent Accord, doivent respecter la législation en vigueur lors de leur séjour sur le territoire de l'autre Partie et les traités internationaux auxquels elles sont parties.

### **Article 5**

Les Parties s'échangent par la voie diplomatique les spécimens de leurs passeports diplomatiques, en cours d'utilisation, nouveaux ou modifiés, et s'informent des conditions d'attribution et d'emploi de ces passeports. Chacune des Parties porte à la connaissance de l'autre Partie toute modification relative à la présentation ou aux conditions d'attribution et d'emploi de ces passeports soixante (60) jours au moins avant sa mise en œuvre, et lui présente les nouveaux spécimens de passeports. Toute perte, vol ou annulation de passeport diplomatique est notifiée à l'autre Partie dans un délai de soixante (60) jours.

### **Article 6**

En cas de divergences portant sur la mise en œuvre du présent Accord, les deux Parties les règlent exclusivement par la voie diplomatique bilatérale.

### **Article 7**

L'application du présent Accord peut être suspendue en totalité ou en partie par l'une ou l'autre des Parties pour des raisons de sécurité nationale, d'ordre public ou de santé publique.

La Partie qui décide de suspendre temporairement, en totalité ou en partie, l'application du présent Accord en informe dûment l'autre Partie par la voie diplomatique.

#### **Article 8**

Le présent Accord est conclu pour une durée indéterminée.

Le présent Accord peut faire l'objet de modifications ou de compléments d'un commun accord des Parties. Ces modifications font partie intégrante du présent Accord et entrent en vigueur conformément à son article 9.

Chacune des Parties peut dénoncer le présent Accord moyennant préavis écrit adressé à l'autre Partie ; cette dénonciation prend effet quatre-vingt-dix jours après la date de réception de ce préavis.

#### **Article 9**

Le présent Accord entre en vigueur le premier jour du deuxième mois suivant la date de la dernière notification, par échange de notes diplomatiques entre les Parties, de l'accomplissement des procédures internes requises pour son entrée en vigueur.

En foi de quoi les soussignés, dûment habilités à cet effet, ont signé le présent Accord.

Fait à Oulan-Bator, le 26 Octobre 2013, en deux exemplaires, chacun en langues mongole et française, les deux textes faisant également foi.

**POUR LE GOUVERNEMENT  
DE LA MONGOLIE**



**POUR LE GOUVERNEMENT  
DE LA REPUBLIQUE FRANÇAISE**

